

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.11.14, №7 (123)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,  
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**

№504

Д.Жаргалсайхан

Эдийн засагч, нийтлэлч

## Атгасан тивүүц буюу ФИНТЕК

## Дарангүй дэглэмийг сөрж гарах ГАРЫН АВЛАГА

IV НҮҮРТ



ДеФакто **ЯРИЛЦАГА**

ТОНИ КВОК

ОЛОН УЛСЫН АВЛИГЫН  
ЭСРЭГ ЗӨВЛӨХ

“ ХОНКОНГИЙН АТГ-ЫН  
1400 АЖИЛТНЫ 1000  
НЬ МӨРДӨГЧ ”

VIII НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН САН

XII НҮҮРТ



Финтек (Fintech=Financial technology) нь харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн шинэ төрлийн үйлчилгээ нэвтрүүлж байгаа үйлчилгээний шинэ, эрлийз (hybrid) салбар. Финтек нь хүний хөрөнгө, мөнгөтэй холбоотой учраас үүсч болох аливаа эрсдлийг нь удирдах шаардлагатай.

Монголд Лэндмн, Ард кредит, Hi-рау зэрэг финтекийн олон компаниуд үйл ажиллагаа явуулж, зарим нь гадаадад үйлчилгээгээ нэвтрүүлж эхэлжээ. Финтекийн гарааны Мобифинанс компани өдөрт 200 мянган удаа, нийт 4 тэрбум төгрөгийн кэнди-цахим мөнгөний гүйлгээ хийж 1.5 сая харилцагчиддаа үйлчилж байна. GSMA гэдэг олон улсын үүрэн утасны 750 операторын холбооноос нэг хүнд ногдох ДНБ нь доогуур, мөн хүн амын нягтрал өндөр орнуудад финтекийн үйлчилгээ илүү хурдан нэвтэрч байгааг тогтоожээ.


### САНХҮҮГИЙН ТЕХНОЛОГИ

Технологийн хувьсгал нь юуны түрүүнд мөнгөний хуримтлал, хөрөнгө оруулалтын хооронд зуучлах замаар эдийн засгийн өсөлтийг хангадаг санхүүгийн салбарт илүү хурдан нөлөөлж, бараа үйлчилгээний эргэлтийг огцом өсгөж иржээ.

Финтек 1.0 эрин үе 1876 онд А.Белл телефоны патентаа бүртгүүлснээс хойш эхлэж, санхүүгийн технологийн шинэ дэд бүтэц тавигджээ. 100 жилийн дараа интернеттэй цуг финтек 2.0 эхлэж, санхүүгийн үйлчилгээний хүртээмж, хэрэглээ огцом өслөө. 2008 оноос ухаалаг гар утас, хөдөлгөөнт интернетийн хамт финтек 3.0 эхэлсэн гэж үздэг. Санхүүгийн үйлчилгээ хялбар, хямд, хурдан (ЗХ) болсноор хүн бүрт хүрч, дэлхий даяар ядуурлыг бууруулахад мэдэгдэхүйц өөрчлөлт гаргаж байна. Финтек 3.0 нь санхүүгийн төлбөр, тооцоо, хадгаламж, зээл, даатгалын үйлчилгээнд шинэ хэлбэрийг нэвтрүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж бидний амьдралын хэмнэлд нөлөөлж байна. ▶▶

- ▶ Цахим мөнгө төлбөрийн хэрэгсэл болсноор картын компаниудад төлдөг 3-5 хувийн төлбөрийг хэмнэх боллоо.

Технологи гагцхүү финтекээр зогсохгүй, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, бүтээгдэхүүний үнэ цэнийн гинжин холбоо, блокчэйн зэрэг шинэ бизнес төрүүлж байна.



Source: Pulse of Fintech 2018, Global Analysis of Investment in Fintech, KPMG International (data provided by PitchBook) January 4, 2019.

KPMG Pulse of Fintech report 2018

## САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Финтек нь банкны үйл ажиллагааг задлан, үндсэн зорилго руу нь төлбөр тооцоо хийх, хөрөнгийг оновчтой байрлуулахад төвлөрүүлж эхэллээ гэж Английн Төв банкны Ерөнхийлөгч М.Карней хэлжээ.

Гар утасны дугаар нь төлбөрийн данс болсноор өмнө нь банкны үйлчилгээ авч чадахгүй байсан олон сая хүн төлбөр тооцоогоо түргэн хийж, зээл авдаг болов. Зүүн Африкийн хэдэн улсуудад М-Pesa гэх цахим төлбөрийн систем нэвтэрч санхүүгийн үйлчилгээнд хувьсгал гаргаад байна. Кени улсад М-Pesa-гийн 110 мянган агент ажиллаж байгаа нь АТМ-н тооноос 40 дахин олон болов гэж Дэлхийн банк мэдээлжээ. Хөгжиж буй орнуудад олон сая хүн хадгаламжтай болсноор үйлдвэрлэл, дэд бүтэц, хүний капиталыг хөгжүүлэхэд

шаардлагатай шинэ хөрөнгө хуримтлагдаж байна.

Дэлхийн онлайн худалдааны тал нь ногддог Хятадад Ali Pay, WeChat Pay компани QR код ашигладаг финтекийн үйлчилгээ нэвтрүүлэв. Өмнөд Солонгос “Kakao Pay”, Тайланд “Siam pay”, Австрали “Au wallet”, АНУ “Apple pay” зэрэг өөр өөрийн финтекийн үйлчилгээ нэвтрүүлээд байна. Монголд олон төрлийн оноо цуглуулдаг төлбөрийн аппликейшн ашиглагдах боллоо. Гэхдээ Монголбанкны зөвшөөрөлтэй, төгрөгөөр баталгаажсан ганцхан цахим мөнгө бол Мобифинанс компанийн кэнди ажээ. Кэндигээр 8000 гаруй байршилд үйлчлүүлэхээс гадна заавал ухаалаг гэхгүй, энгийн гар утасны мессежээр төлбөр тооцоо хийдэг.

## СОРИЛТУУД

Харилцаа холбооны технологийн хувьсгал санхүүгийн салбарт олон шинэ санаачилга, өөрчлөлт нэвтрүүлж байна. Гагцхүү энэ өөрчлөлтийг соргоогоор тусган, хувь хүний нууц, өмч хөрөнгийг хамгаалахтай холбоотой хууль, журмаа түргэн шуурхай шинэчлэн зохицуулж чадахгүй байна.

Финтекийн компаниуд хувь хүнтэй холбоотой мэдээлэл цуглуулдаг, зээлийн мэдээллийн сантай мэдээллээ солилцдог боловч, нууцлалыг нь яаж хамгаалах, хэн хариуцах, ямар хариуцлага, шийтгэл хүлээх зэрэг нь тодорхойгүй байна. Монгол улсад төлбөр тооцоо хийх, цахим мөнгийг төгрөгөөр яаж баталгаажуулах зэргийг зохицуулсан Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2018 оны эхнээс үйлчилж байгаа. Олон нийтэд төлбөр тооцооны үйлчилгээ явуулахын тулд аж ахуйн нэгж тодорхой нөхцлийг ханган Монголбанкнаас зөвшөөрөл авах ёстой. Төлбөр тооцоо нь тасралтгүй, баталгаатай байдлыг хангахын тулд арилжааны банкуудын адил мэдээллийн үндсэн болон нөөц төвтэй байх шаардлагатай юм байна. Тэгтэл финтекийн компаниуд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл аваад, маш их хөрөнгө оруулалт шаардлагатай Монголбанкны дээрх нөхцлүүдийг хангахгүйгээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн финтекийн бүх үйлчилгээ харилцаа холбооны технологи ашигладаг учир Харилцаа холбооны зохицуулах хороо ч бас зохицуулах сонирхолтой ажээ.

Энэ нөхцөлд Монголын финтекийн холбоо бусад орнуудын туршлагаар зохицуулагч бүх байгууллагууд хамтран “sand box” зарчмаар ажиллахыг санал болгов. Бүх

финтекийн компаниудыг элсний тоглоомын талбайд (sand box) оруулж “хашаад”, үйл ажиллагааг нь ажиглан, шинэ санаачилгыг нь дэмжихийн зэрэгцээ, өсөж томрох түвшинд нь тохируулсан зохицуулалт хийхээр тохиролцсон боловч бодитой ажил хийгдсэнгүй хагас жил өнгөрөв.


Цаг алдах тусам цахим мөнгөний орон зайгаа гадаадын компаниудад тавьж өгөх, мөнгөний бодлогоо Монголбанк хянаж чадахгүйд хүрч, монголчууд дахиад л гайхамшигт боломжоо алдах гэж байна. Гадны хөрөнгө оруулалт финтект орж ирдэггүй бөгөөд зүгээр л WeChat монголын банкуудын данстай холбогдоод, эсвэл Facebook Calibra цахим түрийвчээ эзх зээлд нэвтрүүлэхэд л Монгол улс бэлэн бус төлбөр тооцооны хяналтаа автоматаар алдах юм.

Цахим гарын үсгийн хэрэглээг дэмжиж бий болгох, түүнийг баталгаажуулах, заавал биечлэн уулзахгүй гэрээ байгуулахыг цаг үе шаардаж байхад Монгол улсад нотариат нь хоёр гурван зуун жилээр хоцрогдсон хэвээрээ байна. Сангийн яам нь хүртэл Төрийн сангийн гүйлгээг аж ахуйн нэгжээс цаасаар авч байгаа нь арилжааны банкуудаасаа ч хичнээн хол хоцрогдсоныг харуулж байна.

Финтекийн боломжийг бүрэн ашиглаж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд Монгол улс компаниудаа ухаалгаар зохицуулах, тэгэхдээ тэдний шинийг санаачлахыг нь хязгаарлахгүй байх, иргэдийнхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэх шаардлага тулгараад байна.

Шувууг хэт чанга атгавал алчихна, хэт сул бол алдчихна.

**ХӨДӨЛГҮҮРИЙН МӨНХИЙН ҮС**



**TOTAL QUARTZ 9000  
5W-40**



**ДОКТОР АВТО СҮЛЖЭЭ  
ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРААР  
ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ.**

**Холбоо барих утас:** 9411-7143, 9906-6402

 [www.minesup.mn](http://www.minesup.mn)

 @TOTALMongolia

 [fb.com/TOTALMongolia](https://fb.com/TOTALMongolia)

 @TOTALMongolia

Албан Ёсны Дистрибьютор:

**UP**  
**MINES**  
www.minesup.mn

# Дарангуй дэглэмийг сөрж гараж ГАРЫН АВЛАГА

Орчуулсан: Х.Номингэрэл

Эх сурвалж: Mycielski, Martin: The Authoritarian Regime Survival Guide, VerfBlog, 2018/3/26, <https://verfassungsblog.de/the-authoritarian-regime-survival-guide/>

*“Дарангуй дэглэмийг сөрж гарах гарын авлага” гэж нэрлэгдсэн энэхүү бичвэр нь 2017 оны нэгдүгээр сараас анх твиттер сүлжээнд тархаж эхэлсэн “Хайрт Зүүн Европын найзуудаас нь” гэсэн гарын үсэг ба #LearnFromEurope гэсэн хаштагтай олон мянган жиргээнүүдээс санаа авч бичигдсэн юм. Ийм таних тэмдэгтэй жиргээнүүд нь нэг сарын дотор гурван сая хандалт авсан байдаг.*

*Гарын авлага нь АНУ болон бусад олон улсад асар хурдан тархаж, Турк, Филиппин гэх мэтээр олон хэл рүү орчуулагджээ. Эш татсан жижиг хэсэг, товчлолууд нь манай сошиал мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдсэн байдаг ч бүрэн эхээр нь нийтэлж байгаа нь анхны удаа юм.*

*Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс оронд тохиолдож буй ардчиллаас ухрах үзэгдэл хоорондоо маш төстэй үйл явцаар өрнөж буй нь олон судлаач, хэвлэл мэдээллийн ажилтнуудын анхаарлыг татаж байна.*

*Энэхүү гарын авлагад дурдсан алхмууд манай Монгол улсад ч тодорхой ажиглагдаж байна.*

*Гарын авлагын төгсгөл хэсэгт хэрвээ таны эргэн тойронд Дарангуй дэглэмийг дэмжигч найз нөхөд, хамт олон, гэр бүлийнхэн байгаа бол тэдэнтэйгээ хэрхэн харилцах арга замыг заасан нь олзуурхууштай хэсэг.*

## ЭХНИЙ ЖИЛ: ДАРАНГУЙ ДЭГЛЭМИЙН ДОР

### Ямар үйл явдал тохиолдох вэ?

1. Тэд хүмүүсийн айдаст суурилсан кампанит ажил зохион байгуулж, түгшүүрт автуулам цуу яриаг нийгэмд тараан, үнэнийг гуйвуулах замаар эрх мэдэлд хүрнэ. Энэхүү ялалтдаа ардчилсан сонгуулийн замаар хүрнэ. Энэ нь тэдний үйлдэл, үйл ажиллагааг шүүмжлэх бүрт хэлэх хариу тайлбар болох учир болгоомжлоорой. Тэд тогтолцоог өөрчлөхийг “Ард түмэн хүссэн” хэмээн хэлэх болно.

**Ардчилсан тогтолцооны дагуу эрх мэдлийг олж авах нь тэдэнд хууль ёсны хэмжээ хязгаарыг давж, ардчиллыг уландаа гишгэх зөвшөөрөл болохгүй гэдгийг санаарай.**

2. Тэд нийгмийг хувааж, хагаралдуулах замаар захирдаг. Тэдний хүч чадал нь нэгдмэл байдал, нэг дуу хоолой, үзэл баримтлал мөн бол чинийх ч тийм байх хэрэгтэй. Тэд өөрсдийнхөө дэмжигчдийг

“жинхэнэ Америкчууд”, “Эх орончид” гэж нэрлэдэг. Та бүхнийг харин урван тэрслэгчид, төрийн дайсан, эх оронч бус, худалдагдсан элитүүд, эрх мэдлийг дахин олж авахын төлөө тэмцэж байгаа хуучин дэглэмийнхэн гэж ялгана. Тэдний дэмжигчид нь удирдагчдаа сонгосон “Бүрэн эрхт Ард түмэн” байна.

**Та бүхнийг бүлэглэн хуваахыг тэдэнд битгий зөвшөөр. Та бүхэн нэгдмэл нэг ашиг сонирхол бүхий нэг Үндэстэн гэдгээ ямагт санаарай.**

3. Тэд төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхэндээ байлгаж, тэдгээрийг ухуулга сурталчилгааны суваг болгон ашиглана. Тэгээд, хэцүү төвөгтэй хуулиуд болон заналхийллүүдээр дамжуулан бүхий л олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хяналтандаа байлгаж, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахыг оролдоно. Тэд шүүмжлэгч

мэдээллийн хэрэгслийг хориглож, тэднийг “худалч”, “хуурамч мэдээ тараагчид” гэж дуудна. Тэд тэдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг “Ард түмний” эсрэг ажиллаж байгаа “эх оронч бус” гэж цоллоно. (2-г харна уу.)

**“Төрийн дайсан” гэж цоллуулж үйл ажиллагаагаа хориглуулсан, хянуулсан, ажлаасаа халагдсан сэтгүүлч бүрийн төлөө тэмц: Хэвлэлийн эрх чөлөө байхгүй газар эрх чөлөөний итгэл найдвар үгүй.**

4. Тэд эмх замбараагүй байдал үүсгэж, үргэлжийн зөрчилдөөн, аюултай байдлын мэдрэмжийг олон нийтэд төрүүлнэ. Үүнийгээ таны эрх чөлөө болон иргэний чөлөөт байдлыг хязгаарлах шинэ захиргаадалтын хууль тогтоомжийг батлах гол тайлбар болгох болно. Тэд өөрсдийгөө “Ард түмний” сайн сайхны төлөө, таныг хамгаалахын төлөө байгаа мэтээр баг зүүнэ.

**Эмх замбараагүй байдал,**

**хуурамч айдас хүүдсийг давж хар. Нэг л өглөө тоталитари фашист тогтолцоонд сэрэхээсээ өмнө үүнийг илчилж гаргаж тавь.**

5. Тэд үнэнийг гуйвуулж, үйл баримтыг үгүйсгэж, ил тодоор худлаа ярих болно. Тэд баримт факт юу байсныг мартуулж, үнэнийг олж мэдэх хэрэгцээг тань унтраахыг хичээнэ. Тэд “үнэний дараах”, “хувилбарт үйл баримт”-аар тэжээж, мэдлэг болон логикийг сэтгэл хөдлөл болон зохиомол үйл явдлаар солих болно.

**Үргэлж шүүмжлэлтэйгээр тунгаан бодож, үйл баримтыг шалган, үнэнд анхаарлаа хандуул. Үл мэдэхүйг илчил.**

6. Тэд хуурамч, зохиомол “дуулиант асуудлыг”-ийг өдөөн турхирч, олон нийтэд тараана. Тэд сөрөг хүчиндээ ялимгүй жижиг бурууг нялзаан, хэтрүүлэн дэвэргэж галыг улам өдөөнө. Энэ нь зөвхөн тэдний тоталитари дэглэмд хүрэхээр авч хэрэгжүүлэх алхмуудад хууль ёсны харагдуулах баг юм.

**Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тархаж байгаа зохиомол сэдэвт бүү хуурт. (3-г харна уу) Тэдний хийж байгаа гол зүйлд анхаарлаа төвлөрүүл.**

7. Тэд таны уур бухимдлыг дэвэргэх зорилгоор зориуд цочирдом хуулиудыг санаачилна. Та тэр хуулиудтай аль байдгаараа тэмцэж, бүрэн төвлөрөх үед санаатайгаар хойш сууж, танд ялалтын хуурамч мэдрэмжийг бий болгоно. Ингэх зуураа тэд арай бага “нүдэнд өртөх” ч ардчиллыг аажмаар бусниулах хууль тогтоомжийг хүлээн зөвшөөрүүлнэ. (4 болон 6-г харна уу)

**Хамгийн чухал зүйлдээ л анхаарлаа хандуул.**

8. Тэд ардчилал бол цөөнхийг огт хүндэтгэдэггүй зөвхөн олонхын л засаглал мэтээр аашилдаг. Иймээс тэд эмэгтэйчүүд, нийгмийн цөөнх гэх мэт хамгийн өр өвтгөм бүлгийг ашиглан таны зөв бурууг цэгнэх мэдрэмжид халдана.

Тэд нийгэмд гадаадын иргэд болон цагаачид бол “бодит аюул занал” гэсэн ойлголт төрүүлнэ. Арьс

өнгө, шашин, хүйсийн болон бусад цөөнхүүдийг тэдний бүтээхээр зорьж байгаа дүрэм журам болон аюулгүй байдлын дайсан гэж үзнэ. Эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг үгүйсгэж, хүйсийн тэгш байдлыг улам дордуулан, нөхөн үржихүйн эрхэд халдана (7-г харна уу). Энэ нь тэд өөрсдийнх нь дэглэмд эмэгтэйчүүд, нийгмийн цөөнхийн зүгээх учруулж болох аюулыг бүрэн дүүрэн мэдэж байгаа гэсэн үг юм.

**Эмэгтэйчүүд, нийгмийн цөөнх бүлгүүд жинхэнэ ардчилал гэж юу болохыг олон нийтэд сануулахад бэлэн байх ёстой. Энэ бол амаргүй тулаан бөгөөд та ч хамтдаа тэмцэх ёстой.**

9. Тэд шүүх эрх мэдлийг хяналтдаа авахыг оролдоно. Тэд танай хамгийн дээд түвшний шүүхэд халдана. Тэд Үндсэн хуульд харш хууль тогтоомжийг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд Хяналт-тэнцлийн зарчмыг устгана. Шүүх эрх мэдлийг хяналтандаа оруулснаар тэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг тэднийг мөрдөн шалгах гэсэн хэн бүхнийг сүрдүүлэх боломжтой болно.

**Бүхий л хүчээрээ шүүхээ хараат бус, бие даасан байлгахар тэмц. Шүүх бол таны аюулгүй байдлын баталгаа болох хууль дээдлэх, ардчилсан тогтолцооны хамгаалагч юм.**

10. Тэд “таны аюулгүй байдлын үүднээс” гэх нэрийдлээр эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахыг оролдоно. Тэд төрийн аливаа арга хэмжээг давуу үзсэн, эсвэл тодорхой төрөл, үзэл баримтлалыг чухалчилсан хууль тогтоомжуудыг батална. Тэд хэнийг хууль ёсны дагуу жагсаал цуглаан хийхийг шийдэж чадаж байна гэдэг нь үлдсэн хэсгийг хүчээр тарааж, мөрдөн мөшгөх хууль зүйн үндэслэлийг олж авна гэсэн үг.

**Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахыг оролдсон хууль тогтоомжийн эсрэг бүх арга замаар эсэргүүцэн зогс!**

11. Тэд хэлийг гуйвуулж, шинэ үг хэллэг, нэршлийг зохион, цочирдом үг хэллэгийг энгийн зүйл гэж хүлээн авах, ухамсаргүйгээр

хэрэглэх хүртэл дахин давтана. Хулгайч, худалч, урвагч гэсэн үгнүүд шууд л өрсөлдөгчдийг нэрлэх үгс болж, харин Эх оронч эсвэл жинхэнэ Америк хүн гэсэн үгнүүд нь тэдний дагагчдыг илэрхийлнэ (2-г харна уу). Тэдний этгээд үгс нь өөрсдийнхөө дэмжигчдэд хүч өгөх болон өрсөлдөгчдийнхөө уур бухимдлыг аажмаар нэмэгдүүлэх хоёрдмол зорилготой байна.

**Олон нийтийн дунд өрнөж байгаа хэл ярианы өөрчлөлтийн эсрэг тэмц. Үгсийн жинхэнэ утгыг санаж, хэвээр авч үлд!**

12. Тэд таны үндэсний бэлгэ тэмдгүүдийг өөриймшүүлж, өөрсдийнхөө дэглэмд хамаатуулж эрх мэдлийнхээ нэг хэсэг болгож харагдуулна. Тэд туг далбаа, төрийн дуулал, бэлгэ тэмдгүүд танд, хүн бүрт, бүх ард түмэнд тэгш хамаардгийг мартуулахыг хүснэ. Үнэт зүйлсээ битгий булаалга. Тэдний адил өөрсдийнхөө тэмцэлд бэлгэ тэмдгээ ил тод ашигла.

**Бахархалтайгаар үндэсний бэлгэ тэмдгээ үзүүл. Өөрсдийн давуу талаа болго. Улс оронд тань тогтож буй дарангуй дэглэмтэй бэлгэ тэмдгээ бүү хутгуул.**

13. Тэд өөрсдийнхөө хэрэгцээнд нийцэж, тохирохуйц түүхийг дахин зохиохыг оролдож, эл зорилгодоо боловсролын тогтолцоогашиглана. Тэднийг үйл ажиллагаатай нийцэхээргүй түүхийг бичиж, эсвэл одоо амьдарч байгаа хүмүүсийг гутаан доромжилж, нэр хүндийг нь гуйвуулна. Тэд сургуульд зааж буй түүхийн хичээлийн агуулгад анхаарал хандуулж, түүх философиин “зөвхөн цор ганц үнэн хувилбар”-аар залуу ухаан бодлыг усална. Тэд түүх болон хорвоог үзэх үзлийн гуйвуулсан тайлбар, ойлголтоор цэнэглэгдсэн, тэдний үзэл баримтлалыг дэмжих сонгогч-шинэ залуу үеийг өсгөнө.

**Хүүхдийнхээ боловсролыг хамгаал, тэдэнд шүүн тунгаах сэтгэлгээг зааж сурга. Нээлттэй үзэл бодолтой нэгэн болгож, бодит түүх, өв соёлоо хамгаал.**

14. Тэд гадаадын холбоотон, хамтрагчдыг “танд хэрэггүй” гэж ятгах замаар тусгаарлана. “Улсаа дахин хүчирхэг болгоно” гэдэгт

л анхаарлаа төвлөрүүлж, дэлхийн үлдсэн хэсгийг хайхрахгүй үлдээнэ. Өөрсдийнхөө популист амлалтуудаа биелүүлэхийн тулд эдийн засгийг нурааж, хөгжил дэвшил бол хамтын ажиллагаа, хуваалцал, худалдаанд тулгуурладаг илүү том дэлхийн нэг хэсэг гэдэг бодит байдлыг үгүйсгэнэ.

*Аюулгүй байдлаар халхавчилсан ханыг өрж, чинээлэг байдалд хүргэх гүүрийг боомилохыг бүү зөвшөөр.*

15. Тэд эцэст нь сонгуулийн тогтолцоог зальдах аргаа олно. Тэд үүнийгээ алдаа дутагдлыг засах, илүү шударга болгох, дэлхийн жишигт нийцүүлэх эсвэл илүү сайжруулахын тулд хэмээн тайлбарлах болно. Үүнд битгий итгэ. Ашигтай болоод л сонгуулиар оролдож таарна.

*Дарангуй дэглэмийг батлахыг хүсч байгаа сонгуулийн хууль тогтоомжид оруулах аливаа өөрчлөлтийг эсэргүүц. Энэ нь зөвхөн тэдэнд эрх мэдлээ илүү удаан хугацаагаар хадгалахад л туслас болно.*

16. Хамгийн чухал нь хүчтэй, тэвчээртэй бай, тэмц. Түүхийн зөв талд нь зогсож байгаа гэдгээ сана. Ард түмний ачаар түүхэн дэх авторитари, тоталитари, фашист дэглэм бүхэн эцсийн дүндээ нуран унасан юм шүү.

*Хайрт Зүүн Европын найзуудаас нь*

## ДАРАНГУЙ ДЭГЛЭМИЙГ ШАЛГАХ ЖАГСААЛТ

1. Айдас болон популист амлалтуудад үндэслэн сонгуульд ялах
2. “Ард түмний төлөө элитүүдээс эрх мэдлийг булаан авах”
3. Төрийн гол байгууллагуудын чухал албан тушаалуудыг хүчээр булаан авах
4. Чадварыг үл харгалзан эрх мэдэл бүхий албан тушаалуудад дотны хүмүүсээ тавих
5. Шүүмжлэлт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг “худалч, худалдагдсан, Ард түмний эсрэг” зэргээр олон нийтийн тархийг угаах
6. Ард түмэнд шулуухан худлаа ярих
7. Хэвлэл мэдээлэлд мэдээлэл өгөхгүй байх, эсвэл тэднийг мэдээлийн эх сурвалжид нэвтрэх эрхийг сонгож хязгаарлах
8. Хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлаж, олон нийтийн мэдээллийн сувгийг сэмхэн хяналтандаа авах
9. Сөрөг хүчин, эсэргүүцэгчдийг урвагчид, эрх мэдлийг булаан авахыг оролдож байгаа элитүүд хэмээн цоллох
10. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах
11. “Ард түмний төлөө” л төлөө бол Үндсэн хуулийг тойрч гарах боломжтой байдлаар дээд шатны шүүхийг өөрчлөх.
12. Цөөнхийн болон эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарлах
13. Өөрсдийн популист амлалтуудыг богино хугацааны дотор биелүүлэхийн тулд эдийн засгийг золиослох
14. Улсаа дахин хүчирхэгжүүлэх гэдэг шалтгаанаар олон улсын холбоотнууд, хамтрагчдыг холдуулах
15. Илүү сайжруулах гэсэн хуурамч зорилгоор сонгуулийн хууль тогтоомжийг чимээгүй өөрчлөх

*Хайрт Зүүн европын найзуудаас нь*

## ДАРАНГУЙ ДЭГЛЭМИЙН ДОТОР ТЭСЧ ҮЛДЭХ 6 ДҮРЭМ

### Дүрэм 1

Битгий хэнэггүй бай. Энэ бүхэн эцэстээ таныг оролдох л болно. Таны гэр бүл, найз нөхдийг оролдох болно. НЭН ДАРУЙ эсэргүүцлээ илэрхийл. Анхаарал хандуулж байгаагаа тэдэнд үзүүл. ТЭМЦ.

### Дүрэм 2

Тэд АЙДАС БОЛОН ХАРАНХУЙ БҮДҮҮЛЭГ байдалд баярладаг. Айдас хүйдсийг зориуд тарааж байгааг нь илрүүл. Тэдний үндэслэлүүдийн алдаа дутагдлыг харуул. Мэдлэгээ нэмэгдүүл. Эргэн тойронд байгаа хүмүүсээ БОЛОВСРУУЛ. Тэд ҮЙЛ БАРИМТЫГ гуйвуулж, түүхийг дахин бичихийг оролдоно. ТЭДЭНД ҮҮНИЙГ БҮҮ ЗӨВШӨӨР.

### Дүрэм 3

Эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийг зохион байгуул, иргэний нийгмийг дайчил. Тэд нарийн зохион байгуулагдсан тул та ч гэсэн тийм бай. ГУДАМЖУУДЫГ ХҮНЭЭР ДҮҮРГЭ. Тэд олны хүчийг хараад ухарна.

#### **Дүрэм 4**

Жинхэнэ Америкчууд, эх оронч хүмүүс, урвагчид, төрийн дайсан гэж иргэдийг ялгаж АНГИЛАХЫГ тэдэнд бүү зөвшөөр. Та бүхэн итгэл үнэмшил, үзэл бодлыг ялгаагаа үл харгалзан БҮГД иргэд, НЭГ улс. Олон янз байдлаа өөрсдийнхөө ДАВУУ ТАЛ болго. Нийтлэг зорилгынхоо төлөө-Эх орныхоо оршин тогтнол, эрх чөлөө болон ардчиллынхаа төлөө ХАМТДАА зогс.

#### **Дүрэм 5**

Битгий бууж өг, битгий ядарч цуц, битгий дуусахыг нь хүлээ. Өнгөрөн одно гэж битгий найд. ТЭГЭХГҮЙ. Тэд өөрсдийнхөө төлөө ард түмнийг мэхлэн, олон нийтийн бодлыг эргүүлэхийн тулд хэвлэл мэдээллийг хяналтандаа байлган, сонгуулийн тогтолцоог өөрчилнө.

#### **Дүрэм 6**

Хэрэв та тэднийг ухрааж, эсвэл зогсоож чадаагүй бол, дараагийн сонгууль болох үед ардчилал хэвээр байна гэж үзэж байгаа бол дахин тийм этгээдүүдэд ХЭН Ч санал өгөхгүй гэдэгт итгэлтэй болтлоо үзэлцэх хэрэгтэй.

*Хайрт Зүүн Европын найзуудаас нь*

## **ТАНЫ НАЙЗ НӨХӨД, ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН ТАНЬ ДАРАНГУЙ ДЭГЛЭМИЙГ ДЭМЖДЭГ БОЛ ХЭРХЭН ХАРИЛЦАХ ВЭ?**

#### **Дүрэм 1**

Хэдий та тэдний хэлж байгаа зүйлүүд нь ямар ч баримт нотолгоогүйг мэдэж байгаа, эсвэл үнэнийг гутаасан гэж бодож байлаа ч битгий дорд үз. Бүү үл хүндэтгэж харьц. Битгий зааж сурга, харин асуулт асуу. Тэдэнд ямар бэрхшээл тулгарсан, яагаад түүнийг нь авторитари дэглэм шийднэ гэж буйг ойлгохыг хичээ. Хүн ёсоор ижил тэнцүү харьц. Тэд хэлж ярьж байгаа зүйлээ үнэн гэж итгэж байгаа бөгөөд тодорхой учир шалтгаан байж магад.

#### **Дүрэм 2**

Сэтгэл хөдлөлөөр бүү ханд, хэтэрхий хурц, халуун маргаан бүү болго. Эсрэг талынхаа сэтгэл хөдлөлтэй тайван, логиктой байдлаар тэмц. Тэд уурлаж бухимдах тусам та илүү тайван байх хэрэгтэй. Эцэстээ тэд ч гэсэн тайвширна.

#### **Дүрэм 3**

Нийтлэг талууддаа анхаарлаа төвлөрүүл. Та нэг хороололд амьдардаг уу? Нэг компани, нэг салбарт ажилладаг уу? Хамт олон чинь жижиг байх тусам амар. “Бид хамтдаа өөрсдийнхөө төлөө үүнийг хийх ёстой, хэрвээ бид хамтрахгүй л бол бидний хэн нь ч хожихгүй” зэрэг жишээнүүдийг хэл.

#### **Дүрэм 4**

Тэдний хэлийг ашигла, таниас доогуур түвшний, юм мэддэггүй мэтээр бүү дорд үз (1-г харна уу). Тэд харааж зүхвэл та ч гэсэн харааж зүх. Хэрэв тантай хошигнож харьцвал битгий уурлаж бухимд, хошигносон байдлаар хариул. Та үнэндээ тэднээс тийм ч өөр биш гэдгээ харуул (3-г харна уу). Хоёр өөр үелзлэлээс харилцвал хэзээ ч ойлголцохгүй.

#### **Дүрэм 5**

Тэдний мэдээллийн эх сурвалжийг өөртөө битгий бүрэн хаа, тэдний удирдагчид, эрх мэдэлтнүүдээс нь огт бүү нүүр буруул. Тэдний ертөнцийг үзэх үзэл, тактикт нэвтрэх боломж гэж үз. Тэдний үндэслэлд бэлтгэлтэй байх давуу тал гэж үз. Санал нийлэхгүй зүйл гарах, эсвэл худал хуурмагийг олж илрүүлэх бүртээ тайвнаар хүлээн авч, баримт нотолгоотой үндэслэлүүдээр илчилж гарга.

#### **Дүрэм 6**

Тэдэнд шууд нөлөөлөх, сөрөг, бодит хор хөнөөлийг зааж үзүүл. Буруу бодлогууд тэдэнд, тэдний гэр бүл, хүүхэд, найз нөхдөд хэрхэн нөлөөлж байгаа, тэдгээр нь хамт олонд яаж сөргөөр нөлөөлж байгаа талаарх жишээг ол.

#### **Дүрэм 7**

Хэрэв дээрх бүгд бүтэлгүйтвэл битгий бууж өг, найз нөхөд, гэр бүлээ битгий орхи, хөршүүдээсээ битгий зугт. Дарангуйлагчид биднийг хяналтандаа байлгахын тулд үргэлж хагаралдуулахыг хүсдэг гэдгийг сана. Мах шарж идэхдээ тэднийг дууд, пиво уухаар цугла, хэн мэдлээ, тэд магадгүй таныг өөр биш гэдгийг эцэст нь ойлгоно.

*Хайрт Зүүн Европын найзуудаас нь*



**ТОНИ КВОК**  
ОЛОН УЛСЫН АВЛИГЫН  
ЭСРЭГ ЗӨВЛӨХ

## ДеФакто ЯРИЛЦЛАГА

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

# “ХОНКОНГИЙН АТГ-ЫН 1400 АЖИЛТНЫ 1000 НЬ МӨРДӨГЧ”

*Тони Квок Хонконгийн их сургуулийн профессор, авлигатай тэмцэх салбарт нийт 44 жил ажиллаж, дэлхийн 26 оронд ажиллаж байжээ. Тэрээр Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хорооны дэд даргаар болон Азийн хөгжлийн банкны засаглалын нөлөөлөх байдлын үнэлгээний зөвлөхөөр ажиллаж байсан. Тони Квок “Монгол улсын авлигатай тэмцэх чадавхыг сайжруулах техникийн тусалцааны төсөл”-ийн гүйцэтгэгч багийн зөвлөх ахлагчаар ажиллаж байна.*

**Д.Жаргалсайхан:** Та монголд хэд дэх удаагаа ирж байна вэ?

**Тони Квок:** Монгол улсад би 2007 онд анх ирж байсан. Тэр үед намайг Монгол улсад АТГ-ыг байгуулахад тусламж үзүүлээч гэж урин ирүүлсэн юм. Тэр цагаас хойш үндсэндээ нийт 14 удаа ирээд байна. Хамгийн сүүлд 2010 онд ирж байсан юм байна. Тэгэхээр би сүүлийн 9 жилд ирэлгүй байж байгаад энэ удаад дахин ирж байна.

**Д.Ж:** Монгол улс анх Авлигын эсрэг конвенцийг соёрхон баталснаар АТГ байгуулах шаардлагатай болсон. Үүнээс хойш хэдийн 12-13 жил өнгөрсөн байна. Тэгэхээр та өнгөрсөн хугацаанд энэ байгууллагын гаргасан амжилт, үр дүнг хэрхэн харж байгаа вэ?

**Т.К:** Миний хувьд хамгийн анх АТГ-ыг байгуулж байсан эхний гурван жил буюу анх байгуулагдсан 2007 оноос 2010 он хүртэлх хугацааг л сайн мэдэх юм. Өөрөөр хэлбэл, тэр үед би тус байгууллагад хөл дээрээ босоход нь туслаж байлаа. Миний санаж байгаагаар 2007 онд сонирхолтой нэг статистик мэдээлэл байсан.

Тэр үед хийсэн олон нийтийн санал бодлыг тандах судалгааны үр дүнгээр нийт хүн амын 74 хувь нь авлигын нөхцөл байдал монголд маш ноцтой байна гэж үзэж байсан. Улмаар би ажлаа дуусгаад 2010 онд явах үед энэ үзүүлэлт 64 хувь болсон байсан. Тэгэхээр тэр үеийг хүртэл нөхцөл байдал эрс сайжраагүй ч энэ үзүүлэлтийг 10 хувь бууруулж чадсан байсан. Гэхдээ тэр үеэс хойш нөхцөл байдал ямар болж буйг би тэр бүр мэдэхгүй байсан. Гэхдээ энэ удаа боломж гарсан дээр нь би монголд цөөн хэд хоног байх боломж олдоод байна. Энэ үеэрээ олон хүмүүстэй уулзаж ярилцсаны үндсэн дээр ерөнхийдөө миний бодож буйгаар АТГ нь олон нийтийн хүлээж буй тэр хэмжээнд хүртэл сайн ажиллаж чадаагүй мэт харагдаж байна.

Гэхдээ АТГ нь мэдээж ихээхэн чухал ач холбогдол бүхий чиг үүргийг гүйцэтгэсээр байна. Надад хэлж буйгаар бол авлигын хэмжээ багхан ч гэсэн буурсан, ялангуяа бага хэмжээний авлига буурч буй нь олон нийтийн санаа бодлын тандан судалгаагаар харагдаж буй ч авлига нь ноцтой хэмжээнд байгаа гэж үзсэн хэвээр байна. Энэ бол зөвхөн миний таамаг, та магадгүй энэ талаар надаас илүү мэдэж байгаа байх.

**Д.Ж:** Хэрвээ та бодоод үзвэл, анх 2007, дараа нь 2010 онд ирж байж, одоо удахгүй 2020 он болох гэж байна. Миний бодлоор авлига өндөр гэж үзэж буй хувь хэмжээ илүү ч өндөр байгаа. Магадгүй нийт хүн амын 80 хувь нь байх. Бага хэмжээний авлига буурсан ч нөгөө талаар улс төрийн намын санхүүжилттэй холбоотой авлига өссөн гэж үзэж байна. Үүгээр дамжуулан улс төрийн намууд эрх мэдлийг худалдан авч байна. Мөнгөтэй хүмүүс биднийг хуурдаг ийм л нөхцөл үүссэн байна гэж бодож байна.

**Т.К:** Мэдээж би энэ талаар судлан үзнэ. Яагаад гэвэл энэ удаад АХБ-ны ажлын хүрээнд би Монгол улсад ирээд байгаа. Миний ирсэн зорилго нь авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын үр дүнтэй байдлыг тодорхойлох зорилготой. Энэ нь АТГ хэр үр дүнтэй ажиллаж байна, прокурорын байгууллага хэр үр дүнтэй ажиллаж байна, мөн шүүх гээд бүхий л талууд авлигын гэмт хэргийг таслан зогсоох чиглэлээр амжилт гаргаж байна уу гэдгийг судлан тогтоох зорилготой юм. Тэгэхээр би танд 6 сарын дараа энэ тал дээр илүү сайн, бодитой хариулт өгч чадах байх.

**Д.Ж:** Тэгэхээр та үргэлжлүүлэн судалгаа хийгээд 6 сарын дараа тайлангаа гаргана гэсэн үг үү?

**Т.К:** Яг тийм. Би энэ ажлынхаа хүрээнд тулгараад буй ямар асуудлууд байна гэдгийг тодорхойлж, тайландаа тусган, улмаар тухайн асуудлыг

хэрхэн шийдэх, сайжруулах тухай зөвлөмжүүдийг гаргана.

**Д.Ж:** Би сүүлийн 10 жилийн турш авлигын асуудлаар нийтлэл бичиж байна. Бүх томоохон хэргүүдийг судлан энэ талаар бичиж байгаа. Монголд гэхэд хуучин Ерөнхий сайдаар ажиллаж байсан хоёр хүнийг, мөн хуучин Сангийн сайд, төрийн өмчит компаниудын удирдлагуудыг авлигын хэргээр баривчлан саатуулсан. Харамсалтай нь тэднийг нэг сар ч юм уу саатуулан шалгасны дараа зүгээр л суллаад явуулж байна. Хүмүүст ямар ч тайлбар өгөхгүй. Анх саатуулахдаа зарим нэг үндэслэл хэлдэг ч дараа нь юу болсныг бид огт мэдэхгүй үлдэж байна. Та хууль хэрэгжүүлэх ажлын талаар ярилаа, энэ нь мэдээж маш чухал ач холбогдолтой. Өнөөдрийн монголд явагдаж буй авлигын эсрэг тэмцлийн хамгийн сул цэг нь миний бодлоор хууль сахиулах хэсэг нь байх. Хууль сахиулах байгууллагууд нь энэ бүх зүйлтэй холбоотой байгаад байгаа нь хамгийн муу мэдээ болж байна. Ийм л анхдагч дүгнэлт хийгээд байна. Тэгэхээр АТГ-ын үйл ажиллагаан дахь прокурорын үүрэг ролийн талаар яриач. Миний ийнхүү асууж буй шалтгаан нь гэвэл АТГ хоёр жилийн өмнө 400 гаруй хэргийг шалган, прокурорт шилжүүлсэн ч ихэнхийг нь яллахаас татгалзсан. Зөвхөн 20 орчим нь шүүхийн шатанд хүрсэн ч хэн ч шийтгэл хүлээгээгүй. Яаж ингэж болж байна вэ? Энэ тохиолдолд прокурорын байгууллагын үүрэг роль ямар байх вэ?

**Т.К:** Энэ сэдэв бол миний хувьд бас л судлан үзэх ёстой сэдэв. Гэхдээ юуны өмнө сая таны хэлсэн том загастай холбоотой хэргүүд дээрх өөрийн ажигласан зүйлсээс хуваалцъя. Анх албадан саатууллаа гэж мэдээлээд хоёр сарын чимээгүй суллаад, цаашаа ямар ч мэдээлэл байхгүй болдог. Хонконг дахь миний өөрийн туршлагаас мөн бусад гадаад улс орнуудын туршлагаас



үзвэл АТГ-ын хувьд ийм төрлийн том хэрэг дээр мөрдөн байцаалтыг нэг сарын хугацаанд багтаан хийх нь практикийн хувьд бараг боломжгүй юм. Энэ тохиолдолд эдгээр хүмүүсийг суллаж байгаа нь мөрдөн байцаалтын үйл ажиллагаа зогссон гэсэн үг биш. Харин мөрдөн байцаалт үргэлжилж явагдахгүй бол АТГ нь олон нийтэд тайлбарлаж байх ёстой.

АТГ энэ талаар тайлбар хийгээгүй ч тухайн хэргийн мөрдөн байцаалт үргэлжлэн явагдаж байж болох ба мөрдөн байцаалт ямар шалтгааны улмаас, хэрхэн хийж байгааг мэдээлэх нь зөв бус арга зам гэж үзэж байж болно. Миний зүгээс тэр бүр таамаглал дээр үндэслэж болохгүй гэдгийг хэлмээр байна.

Прокурорын хувьд авлигатай тэмцэхэд маш чухал үүргийг гүйцэтгэдэг. Хэрэв сайн, өндөр ур чадвартай прокурортой байвал авлигатай тэмцэх магадлал илүү нэмэгдэнэ. Харин нөгөө талаар ур чадваргүй, чадамжгүй, бүр авлигад автсан прокурор байгаа бол энэ нь авлигатай тэмцэх хамаг боломжийг хаасан хаалт тотгор болно. Би Индонезийн жишээг хуваалцъя.

Одоо Индонезид оюутнуудын эсэргүүцлийн хөдөлгөөн газар авч буйг мэдээгээр гаргаж байгаа. Өргөн хэмжээний эсэргүүцлийн арга хэмжээ. Эсэргүүцэл газар авч буйн шалтгаан нь Парламентаас батлан гаргасан АТГ-ын эрх мэдэл, хараат бус байдлыг бууруулсан шинэ хуулийг эсэргүүцэж байгаа явдал. Тус байгууллагын нэрийг англиар КРК гэж товчлон нэрлэж байгаа. КРК нь бусад орнуудын авлигатай тэмцэх газруудтай харьцуулбал харьцангуй амжилттай үйл ажиллагаа явуулж буй газар. Индонези маш их авлигатай газар байсан гэдгийг бид бүгд мэднэ. 2002 онд олон нийт дарамт шахалт үзүүлсний дүнд энэхүү хараат бус АТГ-ыг байгуулан ажиллуулж эхэлсэн. Улмаар энэ байгууллагад өргөн хүрээний эрх мэдлийг, жишээ нь утасны яриа нууцаар сонсох гэх мэт эрхүүдийг олгосон. АТГ нь ч ажлаа сайн хийсэн. Улмаар ажил үүргээ гүйцэтгэх явцдаа ажилд нь хамгийн гол саад тотгор учруулж буй бөглөө нь прокурорын байгууллага байна гэж АТГ нь үзсэн. АТГ нь ажлаа сайн хийгээд, авлигын хэргийг илрүүлээд, баримт нотолгоог цуглуулаад прокурорт хүргүүлэхээр тэнд саатчихдаг. Тэгэхээр ямар арга хэмжээ авсан гэхээр хуульдаа өөрчлөлт хийж, АТГ-т өөрт нь прокурорын эрх мэдлийг өгсөн. АТГ нь чадамж бүхий эрүүгийн эрх зүйчийг зөвлөхөөр болон прокуророор авч ажиллуулах эрхтэй болсон. Тэгэхээр АТГ нь мөрдөн байцаалтын үйл ажиллагааг явуулж, тэнд ажиллаж буй хуульчид нь прокурорын байр сууринаас хандаж, ялладаг, хяналт тавьдаг болсон. Дараа нь дахиад л асуудал

гарч ирсэн. Авлигажсан шүүгч нартай холбоотой асуудлууд босож ирсэн. Ахиад л шилжүүлсэн хэрэг шүүх дээр саатдаг, ялласан хэргийн тоо хэмжээ ч маш бага байдаг болсон.

**Д.Ж:** Монголд ч бас ийм асуудал болоод байна даа.

**Т.К:** Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авсан бэ гэвэл тус улсад Авлигын хэргийг дагнан шүүдэг тусгай шүүх байгуулсан. Шүүгч нарын дундаас хамгийн тохирсон шүүгчийг сонгож аваад шударга байдлын тестэд хамруулаад авч ажиллуулсан. Мөн гадны эрүүгийн хуульчдыг мөн шүүгчээр бэлтгэн ажиллуулсан. Тэгээд энэхүү тусгай шүүх нь бүхий л авлигын хэргийг хэлэлцэн шийдэх болсон. Тэгээд юу болсон гэж бодож байна? Шүүхэд шилжиж ирсэн хэргийн 90 гаруй хувь нь шийдэгддэг болсон. Өмнө нь ойролцоогоор 50 хувь байсан бол дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд 90 хувь хүрч өссөн түүхтэй. Энэ бол Монгол улсын хувьд судлан үзэх ёстой кэйс гэж үзэж байна.

Дараа нь ямар асуудал гарсан бэ гэхээр АТГ нь ажлаа маш сайн хийж, олон тооны том загас болох улс төрчид, Парламентын гишүүдийг баривчлан, улс төрийн намуудыг авлигын хэргээр буруутгаж эхэлсэн. Энэ нь нөгөө талынхаа дургүйцлийг хүргэж, тэгээд шинэ хариу арга хэмжээ авч эхэлсэн түүхтэй. Засгийн эрхэнд байгаа олонхын суудалтай улс төрийн нам нь шинэ хууль батлан гаргаж, АТГ-ын эрх мэдлийг багасгасан. Эхлээд яаж багасгасан бэ гэхээр Хяналтын зөвлөл гэж байгуулсан. Ерөнхийлөгч нь 5 гишүүнтэй хяналтын зөвлөлийг томилох эрхтэй болгосон. Энэхүү зөвлөл нь АТГ-ын үйл ажиллагааг хянах болсон нь тухайн байгууллагын хараат бус байдлыг бууруулсан хэрэг болсон. Учир нь тэнд Ерөнхийлөгчийн ч хүмүүс томилогдоно. Ерөнхийлөгч нь өөрөө улс төрийн намаас гарсан байгаа. Тэр 5 хүн бүхий л байгууллагыг хянаж байх тэр нөхцөлд энэ хууль хөтлөн хүргэсэн. Хууль оруулсан хоёр дахь өөрчлөлт нь хэрвээ өмнө нь АТГ нь бусдын утасны яриаг нууцаар чагнах хэрэгтэй бол Газрын дарга зөвшөөрөл өгдөг байсан бол одоо энэ шинэ хуулийн өөрчлөлтөөр энэхүү 5 гишүүнтэй зөвлөлөөс зөвшөөрөл авч байж утасны яриа чагнах эрхтэй болж байгаа юм.

**Д.Ж:** Утасны яриа чагнахаас өмнө?

**Т.К:** Мэдээж, энэ байгууллагын эрх мэдлийг бууруулж буй хэрэг болсон. Мөн энэ нь мөрдөж буй хэргийн нууцлалтай ч хамааралтай. Гуравдугаарт, монголтой маш ижил төстэй байдал үүссэн нь хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр мөрдөн байцаалтад буй бүх хэргийн мөрдөн байцаалтыг зогсоох тухай хууль гаргасан. Тухайн хуулиар хоёр жилээс дээш хугацаагаар мөрдөн байцаалтад буй бүх хэргийг хэрэгсэхгүй болгох

шаардлага тавьсан. Монголд үүсээд буй хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудалтай маш ижил төстэй байгаа биз. Үүнтэй яг л ижил зүйл болсон. Тэгээд яасан гэхээр их сургуулийн оюутнууд үүнийг эсэргүүцэж жагсаал хийж эхэлсэн. Улмаар Ерөнхийлөгчийн зүгээс өөрийн хуулийг буцаан татна гэж амласан.

**Д.Ж:** Тэгэхээр тухайн хуулийн хэрэгжилтээ зогсооно гэсэн үг үү?

**Т.К:** Түр хугацаанд. Энэ бол үнэхээр сайн жишээ байж болно. Энэ жишээнээс Монгол улсын хувьд хүндрэлтэй ямар асуудлууд байна гэдгийг бусад улсаас ч харж болох юм. Тухайн асуудлуудын талаар би тантай хуваалцаж ярилцана. Нэгдүгээр асуудал нь үнэхээр улс төрийн дээд түвшний хүсэл зориг байна уу гэсэн асуудал байдаг. Мэдээж бидэнд авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зориг байгаа гэж тэд надад хэлнэ. Гэхдээ жинхэнэ улс төрийн хүсэл зориг байна уу? Улс төрийн дээд шатанд авлигатай тэмцэх хүсэл зориг байгаа эсэхийг хэмжих гурван арга зам байгааг би тайлбарлая. Нэгдүгээрт, АТГ-таа хангалттай хэмжээний нөөц, төсөв, санхүүжилт олгож байна уу? Хонконгтой харьцуулаад үзье. Яагаад авлигатай тэмцэх чиглэлээр амжилт олоод байна вэ? Хонконг дахь манай АТГ-т 1400 ажилтан ажилладаг. 1400 ажилтан шүү дээ. Хонконгын хүн ам 7 сая. Монголд бол 170 ажилтан байна. Монгол улс 3 сая хүн амтай, тийм үү? Тэгэхээр Хонконгын жишээ нь сайн томьёо гэж үзвэл монголын АТГ-т 170 биш харин 700 ажилтан байх ёстой. Хонконгын АТГ-ын 1400 ажилтны 1000 нь мөрдөн байцаагч нар. Тэгэхээр Хонконг авлигын хэргийг 1000 мөрдөгч шалгаж байна гэсэн үг. Мэдээж манайд төр, бизнесийн байгууллагын, банкны болон сонгуулийн үеийн авлигыг ч мөрдөн шалгадаг. Гэхдээ л манайд 1000 мөрдөгч ажиллаж байна. Монголын АТГ хэдэн мөрдөгч ажиллаж байгаа вэ? Та мэдэх үү?

**Д.Ж:** Үгүй ээ. Мэдэхгүй.

**Т.К:** Би танаас илүү мэдэх юм шиг байна. АТГ-т 30 мөрдөгч ажиллаж байгаа. Яаж 30-хан мөрдөгч Монгол улсад үйлдэгдэж буй бүх авлигын хэргийг мөрдөн шалгаж чадах билээ?

**Д.Ж:** Тэгэхээр нэгдүгээрт хангалттай нөөц, санхүүжилт байх нь. Хоёрдугаарт?

**Т.К:** Хоёрдугаарт эрх зүйн орчин байна уу? Энэ нь хангалттай хууль тогтоомжтой байж, хууль ёсны эрх мэдэл хэрэгтэй гэсэн үг. Би үүгээр юу хэлээд байгааг та мэдэж байгаа байх. Хууль тогтоомжид дүн шинжилгээ хийгээд үзэхээр жишээ нь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал байгаад байна. Энэ нь хууль тогтоомж нь муу гэсэн үг. Бид нуур, цөөрмөөс том загас бариад, тэгээд

буцаагаад тавьж буйтай адилхан. Муу хууль нь энэ зүйлд хүргэж байгаа юм.

**Д.Ж:** Энэ хуулиас болоод 400 гаруй хэрэг шийдэгдэхгүй замхран алга болох гээд байна. Одоо УИХ дээр үүнийг үргэлжлүүлэх үү, яах вэ гээд хэлэлцэж байгаа ч ямар нэгэн үр дүнг бид хараахан хараагүй л байна.

**Т.К:** Энэ чинь Индонезийн жишээтэй ижил төстэй гэж болох зүйл болж байна. Улс төрийн хүсэл зориг буй эсэхийг хэмждэг гурав дахь арга нь улс төрийн хөндлөнгийн оролцоо. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд улс төрийн хөндлөнгийн оролцоо их байна уу гэдгийг хэмжиж болно. Хэрэв АТГ нь улс төрчдөөс, олон нийтээс их гомдол хүлээн авдаг, улс төрчдийн хөндлөнгийн оролцоо ихтэй бол хэргийг мөрдөн шалгаж чадахгүй. Хэрэв Хонконгт хэн нэгэн этгээд хөндлөнгөөс нөлөөлөх гэж оролдвол шоронд орно. Өөрөөр хэлбэл хуулийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулсан гэдэг үндэслэлээр. Саяхан 2 жилийн өмнө болсон тохиолдол байгаа л даа. Маш өндөр түвшний улс төрч, өөрөөр хэлбэл Бүх Хятадын АИХ-ын гишүүн хүн байсан. Энэхүү Хятадын хууль тогтоох дээд байгууллагад ойролцоогоор 30 орчим Хонконгийн төлөөлөгч сонгогддог. Эдний нэг нь Хонконгт өөрийн компанитай, АТГ нь тэрхүү компани дээр мөрдөн байцаалт явуулж байсан. Тэрээр Хонконгийн Ерөнхий захирагч руу цахим шуудан илгээж, өөрийнх нь компанийг мөрдөн шалгаж болохгүй, ажлаа зогсоо гэж шаардсан байна. Тэгээд яасан гэхээр Хонконгийн захирагч түүний явуулсан цахим шууданг АТГ-т хүргүүлээд, дараа өдөр нь АТГ-ын ажилтан тэрхүү БХАИХ-ын гишүүнийг баривчлан саатуулсан. Улмаар түүнийг хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саад учруулсан гэсэн үндэслэлээр ялласан. 2 жил хоригдох ялаар шийтгэгдсэн. Энэ бол их чухал зүйл. Бид хараат бус байдал гээд яриад байдаг, улс төрийн хөндлөнгийн оролцоо гээд яриад л байдаг ч хараат бус байдал хангагдаагүй байдгаас үүдэж байгаа юм. Хараат бус байдал гэдэг нь маш чухал. Энэ нь үндсэндээ баталгаа юм шүү дээ.

**Д.Ж:** Монголд болохоор хэн нэгэн нөлөө бүхий этгээд шүүгч рүү ч юм уу, АТГ-ын ажилтантай уулзаад л нөлөөлж байдаг.

**Т.К:** Хонконгт ч гэсэн энэ явдал тохиолддог байх нь.

**Д.Ж:** Танайд бол утсаар ярих л юм бол гэмт хэрэгт тооцох нь ээ?

**Т.К:** Тийм, гэмт хэрэг.

**Д.Ж:** Тэр этгээд тэгээд 20 хоног баривчлагдсан байна, тийм үү?

**Т.К:** 20 хоног биш, 2 жил. Үндсэндээ бол энэ төрлийн гэмт хэрэгт оноох ялын дээд хэмжээ гэж байхгүй. Нийтийн эрх зүйн хуультай тогтолцоонд шударга ёс тогтооход

саад учруулах нь гэмт хэрэг гэж тооцогдож, тэр ч байтугай бүх насаар нь хорих ял ч өгөх боломжтой. Танд ярьсан жишээний хувьд бол 2 жилийн хорих ял авсан. Зөвхөн цахим шуудан явуулсан хэргээр шүү дээ. Цахим шуудан явуулаад мөрдөн байцаалтыг зогсоох хүсэлт гаргаад 2 жил хорих ял.

Тэгэхээр Монгол улсад хууль сахиулах үйл ажиллагаанд саад тотгор учруулах гэсэн үндэслэлийг багтаасан хууль гаргах хэрэгтэй. Үүнийг ч НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн хүрээнд зөвлөмж болгодог. Учир нь НҮБ-ын Конвенц энэ болон бусад асуудлуудын талаар сайн мэдэж байгаа учраас тэр. Тэгэхээр улс төрийн хөндлөнгийн оролцоог хязгаарласан хууль байх ёстой.

**Д.Ж:** Та мэдэж байгаа байх. Энэ бүх авлигын хэргүүд нь хөгжлийг зогсоож, хэн ч шийтгэл хүлээхгүйн улмаас хүмүүсийн төрийн тогтолцоонд итгэх итгэл үнэмшлийг сөнөөж байна. Үүнээс үүдээд хүмүүс маргаашдаа итгэлгүй ийм л байдалд амьдарч байна. Хүмүүс энэ улсаас зугтаж, ямар нэгэн аргаар өөр улс оронд очиж ажиллахаар явцгаах болоод байна. Солонгос, Швед, Европ гээд л ямар ч хамаагүй аргаар тийшээ зүглэх болоод байна.

**Т.К:** Би нэг маш чухал зүйлийг хэлэхийг хүсч байна. Хонконгийн АТГ-ын тухай ярихаар Хонконг баян газар болохоор тэр хэмжээний зардлыг даах чадвартай гэж боддог. Би танд үнэнийг хэлэх гэж байна. Хонконгийн АТГ-ын нийт төсөв нь буюу авлигатай тэмцэх төсөв нь Хонконгийн нийт төсвийн 0.18 хувьтай тэнцүү байдаг. Энэ маш чухал. 0.18 хувь. Эдийн засагч хүний хувьд та үүнийг ойлгож байгаа байх. Авлигаас үүдэн Засгийн газар хэр хэмжээний мөнгийг алдаж болох вэ? Жишээ нь нийт төсвийн 10 хувь нь авлигаас үүдэн алга болж байна. Бүр 10-аас ч илүү хувийг алдаж болно. Тэгэхээр эдийн засгийн үүднээс авч үзвэл Засгийн газар өөрийн төсвийн 0.18 хувийг авлигатай тэмцэхэд зарцуулвал нийт төсвийн 10 хувийг хэмнэх боломжтой.

**Д.Ж:** Маш логиктой сонсогдож байна.

**Т.К:** Магадгүй та надад шалгаад өгч болох юм. Монголын АТГ-ын төсөв, магадгүй бусад олон тооны авлигажсан улс оронтой ижил байгаа байх. Магадгүй 0.01 хувь байх. Та шалгаад үзээрэй. Энэ нь их сонирхолтой үзүүлэлт гэсэн үг л дээ. Авлигатай тэмцэхийг хүсч байна гэсэн удирдагчтай байгаа ч төсвийнхөө 0.01 хувийг л үүнд зарцуулахад бэлэн, харин өөрийнхөө аюулгүй байдал, хамгаалалтад нийт төсвийн 5, эсвэл 10 хувь зарцуулдаг байвал яах вэ?

**Д.Ж:** Хонконгийн АТГ-ын даргыг хэн нэр дэвшүүлэн томилдог вэ? Ямар хугацаагаар?

**Т.К:** Энэ их сонирхолтой. Хонконгийн жишээг бүү дага, учир нь энэ бол Сингапурын жишээнээс авсан тогтолцоо. Сингапур нь хамгийн анх АТГ байгуулсан улс л даа. Дараа нь Малайз, Хонконг байгуулсан. Тэр үед Хонконг нь Сингапурын жишээг дагасан ч энэ нь хамгийн сайн жишээ биш. Учир нь бид хараат бус гэж байгаа ч АТГ нь Хонконгийн захирагчид шууд захирагддаг. Тэгэхээр Засгийн газар энэ байгууллагын тэргүүнийг томилж, чөлөөлдөг гэсэн үг. Энэ бол хамгийн сайн систем биш. Хэрвээ Захирагч нь сайн байвал бүх зүйл болно гэсэн үг. Гэтэл хэрэв Ерөнхий сайд маань өөрөө сайн бус бол, жишээ нь би энд шууд хэлье. Малайз улс байна. Ерөнхий сайд нь өөрөө тийм ч сайн хүн бус, тэгэхээр АТГ-ынх нь үйл ажиллагаа сайнгүй л байгаа. Тэгэхээр Хонконгийн жишээг бүү дагаарай. Гэхдээ л бид хараат бус байдлыг харьцангуй сайн хангаж буй нь захирагч нь сайн хүн байгаатай л холбоотой. Энэ тохиолдолд систем хэвийн ажиллаж болно. Гэхдээ сайжруулах хэрэгцээ байгаа.

**Д.Ж:** Манайд тулгараад буй асуудал гэвэл АТГ-ын даргыг Ерөнхийлөгч санал болгон нэр дэвшүүлдэгт байгаа юм. Бид энэ системийг өөрчлөхийг хүсч буй ч хараахан амжаагүй л байна. Энэ нь бас л Ерөнхийлөгчөөс шалтгаална. Хэр шударга хүн бэ гэдгээс. Заримдаа Ерөнхийлөгч ард иргэдийн тухай бус, өөрийн сайн сайхны тухай бодоод байдаг мэт санагддаг. Энэ нөхцөлд хийж буй бүхий л ажил нь ердөө л шуоны хэлбэртэй байгаа юм. Гэхдээ нөгөө талаар шударга ёсыг тогтоохыг үнэхээр хүсч буй хүмүүс байна. Гэхдээ энэ систем нь нэг л сайн болж өгөхгүй байна, та ч бас энэ талаар дурдсанд баяртай байна.

**Т.К:** Дараагийн нэг чухал зүйл нь АТГ-ын даргын ажиллах хугацаа нь баталгаатай байх явдал юм. Хэрэв дарга баталгаагүй л байх юм бол түүнийг хэн ч ажлаас нь өөрчлөх боломжтой гэсэн үг.

**Д.Ж:** Манайд яг ийм зүйл болж байна.

**Т.К:** Хэрэв хараат бус байдал байхгүй бол АТГ-ын дарга нь хөндлөнгийн нөлөөнд өртөмтгий байна гэсэн үг. Та нарт үүнээс л зайлсхийх систем хэрэгтэй. Миний үзэж мэдсэнээр хамгийн сайн систем бол Ерөнхийлөгчийн зүгээс сонгон шалгаруулах хороо байгуулж зөв нэр дэвшигчийг сонгох, улмаар сонгосон нэр дэвшигчийг Ерөнхийлөгч зөвшөөрөөд Парламентдаа өргөн мэдүүлж сонгодог байх хэрэгтэй. Мөн Парламент хориг арга хэмжээ авах, татгалзах боломжтой байж даргыг 3-5 жил гэдэг ч юм уу тодорхой заасан хугацаагаар томилдог байх нь зөв. Харин энэ 3-5 жилийн хугацаанд түүнийг үүрэгт амлаас нь чөлөөлж болохгүй. Зөвхөн импичмент маягийн

процессын хүрээнд л хугацаанаас нь өмнө чөлөөлөх боломжтой байх нь зөв. Зөвхөн Парламент гуравны хоёрын саналаар АТГ-ын даргад импичмент тооцох боломжтой байх нь зөв. Энэ тохиолдолд АТГ-ын дарга нь хэн нэгний талаар санаа зовох огт шаардлагагүй болно. Хэрэв дарга нь гэмт хэрэг үйлдэх ч юм уу, ийм тохиолдолд Парламент нь импичмент тооцох боломжтой байна. Ингэх юм бол хамгийн тохиромжтой систем болно.

**Д.Ж:** Манайд эсрэгээрээ л болоод байна. Та сая монголд сонгон шалгаруулах хороо байгуулах хэрэгтэй гэж хэллээ. Тэгэхгүй бол нөгөө шийдвэр гаргагч маань хэн нэгнийг сонгож аваад л яагаад сонгосон болохоо тайлбарлаад л болчихож байгаа юм. Энэ их сайхан санаа байна.

**Т.К:** Сонголт нь мөн ил тод хийгдэх ёстой. Жишээ нь Филиппинд сонгон шалгаруулах хороо болон бүхий л үйл явц нь ил тод хийгддэг. 5 нэр дэвшигч байлаа гэхэд бүх нэр дэвшигчийн тухай мэдээллийг нийтлүүлнэ. Улмаар олон нийт эдгээр нэр дэвшигчээс татгалзаж, дэмжихгүй гэдгээ илэрхийлж болно. Жишээ нь олон нийтийн төлөөлөл энэ хүн чинь асуудалтай гэх мэтээр саналаа илэрхийлэх боломжтой.

Хороо нь эдгээр гарч буй бүхий л эсэргүүцлийг шалгах, судлах үүрэгтэй байдаг. Дараа нь яг АНУ-д болдог шиг сонголын арга хэмжээг явуулна. Нэр дэвшигч нар сонголд оролцож, гарсан асуултаудад хариулт өгөх байдлаар явагдана. Яг ийм байдлаар гаргах ба ямартай ч олон нийтийн санаа бодлыг энд харгалздаг. Энэ бүх зүйл энгийн, ил тод байх шаардлагатай. Хариуцлагатай байх ёстой.

**Д.Ж:** Би ярьж байгаа сэдвээс бага зэрэг хазайсан өөр нэг асуулт асуумаар байна. Зарим улсад омбудсманы систем гэж байдаг. Хувь хүн ч омбудсман байж болдог. Энэ талаар та юу хэлэх вэ?

**Т.К:** Омбудсман бол сайн л систем. Энэ нь төрийн шударга байдлыг баталгаажуулахад тусалдаг нэмэлт систем гэж үзэж болно. Хонконгт бас омбудсман байгаа. Омбудсман нь хоёр тусдаа чиг үүргийг гүйцэтгэдэг. Нэгдүгээрт омбудсман нь захиргааны даган мөрдөлтийг хянах үүрэг байна. Нөгөө нь захиргааны асуудлыг шийддэг. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлэхдээ хойрго, үл тоомсорлосон, татгалзсан, эсвэл төрийн мөнгийг буруу зарцуулах зэрэг захиргааны хэргийг омбудсман шийднэ. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг гэж үзэхгүй захиргааны асуудлыг хариуцна. Харин авлига, залилан гэх мэт эрүүгийн хариуцлага хүлээлгэх үйлдэл дээр АТГ нь ажиллана. Эдгээрийн хоорондын чиг үүргийн зааг ялгаа нь маш

тодорхой. Мэдээж мөн аудитын хороо ч бас ажилладаг.

**Д.Ж:** Монгол улсын хувьд омбудсман болон эрүүгийн гэмт хэрэг хооронд ажиллах ялгааг сайн гаргах шаардлагатай байна. Хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол сахилгын арга хэмжээ авдаг боломжтой байх шаардлагатай байна.

**Т.К:** Энэ хооронд маш тодорхой зааг ялгаа байх ёстой.

**Д.Ж:** Монголд энэ зүйл дутагдаад байна.

**Т.К:** Магадгүй Монгол улсад ийм төрлийн институц л цаашид хэрэгтэй байх.

**Д.Ж:** Тэгэлгүй яах вэ. Цаг бага, ярилцлага богинохон болохоор би асуултаа асуух хэрэгтэй байна. Одоо би таны оролцож байсан ажиллагааны талаар асуумаар байна. Танай баг тухайн үедээ хамгийн том гэж хэлж болох томоохон залилангийн хэргийг илрүүлж байсан. Хонконг дахь арилжааны банк оролцсон хэрэг гээд. Ер нь Хонконг бол тухайн үедээ хамгийн их авлигажсан газрын нэг байсан бол өнөөдөр авлигагүйгээр тэргүүлэх улсын нэг болоод байна. Үүний нууц нь юу байна?

**Т.К:** Тэгэхээр би та бүхэнд хүргэх гол мессежээ хүргэе. Үүнийг Монгол улсад зориулж хэлж буй бөгөөд та бүхэн хийж гүйцэтгэх боломжтой зүйлс юм. 1970-аад оны үед Хонконг бол хамгийн их авлигажсан газар байсан. Бид тэр үед “Авлига биднээс хэийн хэвлийгээс эхлээд авсанд ортол салахгүй” гэж ярьдаг байлаа. Өөрөөр хэлбэл, төрснөөсөө эхлээд үхэх хүртлээ авлига өгөх хэрэгтэй гэсэн үг. Одоо бол өөрчлөгдсөн. Тэгэхээр үндсэндээ танайд эрх бүхий, чадвартай АТГ байх хэрэгтэй. Төсөв, нөөцгээд бүх зүйлээр дэмжиж өгөх улс төрийн хүсэл зориг хэрэгтэй. Улмаар та бүхэн маш сайн стратегитай байх ёстой. Манайд баримталдаг стратеги байгаа. Бид хамгийн анх гурван чиглэлт стратегийг хэрэгжүүлсэн улс л даа. Тэгэхээр авлигатай тэмцэхийн тулд хууль сахиулах арга хэмжээ нэгдүгээрт орно. Маш чухал. Үүний нэгэн адил урьдчилан сэргийлэх нь мөн л чухал. Үүний тулд систем бий болгох хэрэгтэй гэсэн үг. Түүнчлэн олон нийтийн боловсрол. Мөн л чухал стратеги. Энэ нь хүмүүсийн сэтгэлгээг өөрчилж, авлига авах хүсэлгүй болгодог. Та бүхэнд авлигатай тэмцэх иж бүрэн гурван чиглэлт стратеги хандлага шаардлагатай. Өөр нэг маш чухал зүйл нь бүх талууд үүнд оролцох шаардлагатай.

Үүнийг дангаараа хийж чадахгүй тул бүх талууд оролцох ёстой. Миний энд байх үеийн хамгийн том амжилт бол Ерөнхий сайдад Засгийн газрын семинар зохион байгуулах талаар ярилцан, итгүүлсэн явдал байх. Энэ нь бүр яам, газруудыг өөрийн гэсэн авлигын эсрэг үйл ажиллагааны

төлөвлөгөөтэй болгох үйл ажиллагаа гэж үзэж болно. Энэ төлөвлөгөөг жил тутам судлан үзэж байх ёстой. Энэ нь яам, газруудын сайд, дарга нарт өөрийн гэр орноо цэвэршүүл гэсэн хариуцлага үүрүүлж байна гэсэн үг юм. Гэхдээ одоо энэ чилэлээр юу хийгдэж байгааг би сайн мэдэхгүй байна. Хэрэв ийм үйл ажиллагаа явагдаж байгаа бол энэ нь тодорхой үе шаттайгаар сайжраад явж байх ёстой гэж хүлээж байна.

**Д.Ж:** Олон Засгийн газар төлөвлөгөө гаргачихаад л үүнийгээ мартчихдаг л даа. Манай Засгийн газрууд дандаа л ирээдүйн тухай яриадаг байгаа. Одоогийн тухай биш, өнгөрсний тухай ч биш. Таны очиж байсан бусад улсуудтай харьцуулвал Монгол улсын нөхцөл байдал ямар байна гэж үзэж байна вэ?

**Т.К:** Миний бодлоор Монгол улс мэдээж хамгийн муугийн тоонд орохгүй. Хэрэв та бүхэн авлигийн талаарх санал бодлын индексийг үзвэл улс орнуудын 70 гаруй хувь нь дунджаас доогуур байгаа, олон улс өөрсдийгөө цэвэрхэн гэж үздэггүй. Ямартай ч Монгол улс хамгийн муу нь биш. Гэхдээ миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл Монгол улсад улс төрийн зөв хүсэл зориг байвал хүмүүс үүнийг дэмжих болно гэж хэлмээр байна.

**Д.Ж:** Сүүлийн асуулт. Яагаад бид авлигатай бүхий л арга замаар тэмцэх ёстой вэ?

**Т.К:** Үүнд та надаас илүү хариулах байх. Мэдээж авлига манай хуулийн засаглалыг гажуудуулж, ардчилсан системийг доголдуулж, эдийн засгийг доройтуулж, шударга бус байдлыг бий болгодог гээд тодорхой. Миний бодлоор эдгээр нь тийм ч чухал бус. Хүн бүхэн авлига бол муу зүйл гэдгийг мэднэ. Харин үүнийг хэрхэн засан залруулах вэ гэдэг нь асуудал болоод байна. Бид үүн дээр л төвлөрөх ёстой.

**Д.Ж:** Бидний ярилцлагыг хэрэв зөв ойлгоод зөв ашиглавал авлигатай тэмцэхэд их хувь нэмэр болно гэж бодож байна. Энэ бүх ажлыг хийж гүйцэтгэж, Монгол улсын АТГ-т олон жилийн туршид зөвлөж байгаад талархлаа илэрхийлье. Танд маш их баярлалаа.

**Т.К:** Баярлалаа.

2019.10.26

Ярилцлагыг [www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com) вебсайтаас үзэх боломжтой.



## ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:  
2019.11.10-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН САН

“Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ санаачилж Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум, Бодлогод залуусын хяналт ТББ зэрэг байгууллагуудын дэмжлэгтэйгээр бүтсэн төрийн таван байгууллагын нээлттэй мэдээллийг нэгтгэсэн <http://opendatalab.mn/> хайлтын системийг танилцууллаа. Энэ хайлтын системд

- хөрөнгө, орлогын мэдүүлэг
- худалдан авах ажиллагаа
- улсын бүртгэл
- уул уурхайн лиценз
- сонгууль гэсэн категори бүхий 197085 байгууллага, 489494 хувь хүн, 17026 тендер, 73189 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг, 3356 уул уурхайн лиценз, 16 визуал дата, бүх сонгуулийн мэдээллийг нэгтгэж олон нийт хэрэглэхэд хялбар болгожээ.

Мэдээллийн технологийг ашиглан ийм нэгдсэн том портал гаргаж байгаа нь дэвшил мөн. Скандиновын орнуудад бол мэдээлэл маш нээлттэй байдаг ба үүгээрээ Засгийн газар болон иргэдийн хоорондын харилцаа маш зөв түвшинд байдаг. Иргэдийн итгэлцэл нэмэгдэж, хүлээлт нэг түвшинд хүрдэг.

Төслийг санаачлагч Г.Батдорж “Нэгэн жишээ дурдахад бид хөрөнгө оруулгын мэдээлэлд бүртгэлтэй бүх төрийн албан хаагчдын хадгаламжийг албан тушаалаар нь ангилж үзсэн. Ингээд үзэхэд нийт хадгаламжийн 50 хувийг УИХ-ын болон иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд эзлэж байна. Энэ нь Монгол улсын нийт хадгаламжийн 9 хувь гэсэн үг.”

АТГ-ын ажилтан Д.Цэнд-Аюуш “Өнгөрсөн оны УИХ-ын гишүүдийн хөрөнгө орлогын мэдээлэлд нийтдээ 39 орчим тэрбум төгрөгийн орлого олсон гэж мэдүүлсэн. Үүнийг нэг гишүүнд хуваавал сардаа 44 сая төгрөг ногдож байна.”

Монгол улс анх Авлигын эсрэг конвенцийг соёрхон баталснаар АТГ байгуулах шаардлагатай болж 2007 онд байгуулсан. 2019 оны эхний хагаст Авлигатай тэмцэх газар хуульд заасан харьяаллын 984 үйлдэлтэй, 283 холбогдогчтой, 834 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан. Гэмт хэргийн улмаас 11.9 их наяд төгрөгийн хохирол учирсан. 11.9 их наяд төгрөгийн хохирол учруулчихаад байгаа 834 хэргийн 9.4 хувийг шүүхэд шилжүүлж, 36.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, 6.1 хувийг харьяаллын дагуу

шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлжээ. Ерөнхийдөө мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 53.7 хувьтай байгаа аж. Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 10.2 хувийг төрийн улс төрийн, 16.3 хувийг төрийн захиргааны, 24 хувийг төрийн тусгай, 9.9 хувийг төрийн үйлчилгээний, 12.4 хувийг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн албан тушаалтан эзэлжээ. Үндсэндээ авлигын хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийн 72.8 хувийг төрийн албан тушаалтан эзлэж байна. АТГ хоёр жилийн өмнө 400 гаруй хэргийг шалган, прокурорт шилжүүлсэн ч ихэнхийг нь яллахаас татгалзсан. Зөвхөн 20 орчим нь шүүхийн шатанд хүрсэн ч хэн ч шийтгэл хүлээгээгүй.

АТГ-аас өгч байгаа мэдээллээр, энэ оны эхний хагаст авлигын гэмт хэргийн улмаас учирсан 11.9 их наяд төгрөгийн хохирлоос мөрдөн шалгах ажиллагааны явцад 376 саяыг нь нөхөн төлүүлсэн байна. Харин 129.8 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх үл хөдлөх, хөдлөх хөрөнгө, автомашин, тоног төхөөрөмж болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Энэ нь 11.9 их наяд төгрөгийн хохирлоос ердөө 130 тэрбум буюу 1.3 ч хүрэхгүй хувийг нь эргэн төлүүлсэн гэсэн үг. Битүүмжилсэн хөрөнгийг яг төлсөн гэж тооцохгүй бол эргэн төлүүлсэн мөнгө 0.1 хувьд ч хүрэхгүй гэсэн үг юм. 2018 онд авлигачдын учруулсан хохирол 2017 оныхоос 10 дахин өссөн. Түүнээс гадна, 11 жилийн хугацаанд авлигын улмаас улсад учирсан 800 гаруй тэрбум төгрөгийн хохирлын 75 хувийг 2018 оны хохирол эзлэж байна. Үндсэндээ 2018, 2019 онд авлигын гэмт хэргээс учирсан хохирол 12.5 их наяд төгрөгт хүрчихсэн байна. Энэ бол зөвхөн мөрдөн шалгах ажиллагааны үед л гарч ирсэн тоо юм. Тэгэхээр хэргүүд шийдвэрлэгдэхэд 11.9 их наяд төгрөг хэд ч болж буурах боломжтой.

Энэ вебсайтад шийдвэрлэж байгаа авлигын хэргийн статистик мэдээллийг нэмж оруулах хэрэгтэй санагдаж байна. Шүүх засаглалыг сайжруулна гэж яриад байгаагийн эхлэл энэ. Авлигын хэргүүдийг хаанахын хэн гэдэг прокурор хэрхэн яллаж, шүүгч яаж шийдсэн эсвэл шийдээгүй баримтууд байх ёстой. Мөн төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдээллээс гадна түүний зарлагын мэдээлэл байх хэрэгтэй.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв  
Тоймын бүрэн эхийг [jargaldefacto.com](http://jargaldefacto.com) вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл

[www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com) болон [www.defacto.mn](http://www.defacto.mn) вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

### РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:  
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:  
Ганбаатарын Жавзмаа

### ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн  
Адьяагийн Тунгалаг

### ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com  
☎ +976 94109342  
🌐 [www.defacto.mn](http://www.defacto.mn)  
[www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com)